

Бизнес төлөвлөгөө боловсруулах аргачлал






ШИНЖЛЭХ УХААНЫ ПАРК
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Бизнес төлөвлөгөө гэж юу вэ?



Бизнес төлөвлөгөө гэж юу вэ?

Бизнес төлөвлөгөө бол бизнес ба түүний орчин, удирдлагын систем, зах зээл, тухайн компаний өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд шаардагдах нөөц, зорилтот үр дүнд хүрэх арга замыг тодорхойлж бичсэн баримт бичиг юм.



**Бизнес төлөвлөгөөг боловсруулахаас
өмнө бизнес эрхлэгч та дараах
асуултуудыг өөрөөсөө асуух хэрэгтэй**



Өөрөөсөө асуух асуулт?



1. Ямар бизнес эрхлэх гэж байгаа вэ?



2. Энэ бизнесийг эрхлэх болсон шалтгаан юу вэ?

3. Энэ бизнесийн хэрэглэгчид, өрсөлдөгчид нь хэн байх вэ? Шинэ бизнес хэрэглэгчдийн таашаалыг хэрхэн хангаж өрсөлдөгчтэй өрсөлдөх вэ?

4. Энэ бизнесийг төлөвлөж, үйл ажиллагаа явуулах хамгийн оновчтой арга зам юу вэ? Таньд ямар нөөц бололцоо байгаа вэ?

5. Санхүүгийн талаас үнэхээр ашигтай ажиллаж чадах уу? Хэдий хугацаанд ашигтай ажиллах вэ? Тогтвортой ашигтай ажиллуулахын тулд ямар хөрөнгө, эх үүсвэр шаардагдах вэ?





Бизнес төлөвлөгөө



Бизнес төлөвлөгөөний үүрэг

Бизнесийн стратегийг
боловсруулахад ашиглах



Төлөвлөлт

Хөрөнгө оруулалт татах



Байгууллагын төлөвлөгөөг
хэрэгжүүлэхэд үйлдвэрлэлд хувь
хөрөнгөө эсвэл өөрийн технологио
нийлүүлэх хамтран ажиллахыг
сонирхож буй этгээдүүдийг татах



Бизнес төлөвлөгөөний 7-н ач холбогдол



Ач холбогдол



1. Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд этгээд болох, жишээлбэл компанийн удирдлагын баг, ерөнхий гүйцэтгэх ажилтан нь төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлвэл бизнестээ амжилт гаргахад илүү тустай.

2. Бизнес төлөвлөгөөг зөвхөн санхүүжилт олох зорилгоор биш үйл ажиллагаагаа төлөвлөгөөний дагуу зөв зохистой явуулах үүднээс хийх хэрэгтэй. Бизнес төлөвлөгөөг нягт нямбай, зөв хийх нь алдаа гаргаж алдагдалд орохоос сэргийлнэ.

3. Санхүүгийн жил бүр /1жил/ бизнес төлөвлөгөө боловсруулж, ирэх жилд явуулах үйл ажиллагаа төлөвлөснөөр бизнесийн ашиг орлогоо нэмэгдүүлэх, бизнесээ зөв амжилттай удирдан зохион байгуулах гол үндэс нь болдог.

4. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнд зах зээл, эрэлт бий эсэхийг сайн судлаж шалгах төлөвлөх шаардлагатай.

5. Бизнес төлөвлөгөөний санхүүгийн хэсэгт хөрөнгийг хэрхэн төлөвлөж зарцуулахыг харуулах мөнгөн урсгалын тооцоог заавал оруулсан байх шаардлагатай.

6. Зардлууд нь бодитой, хэмнэсэн байх бөгөөд зохиогчийн бодит нөхцөл байдлын тухай ойлголтыг аль болох нарийн гаргавал зохино.

7. Жил бүрийн бизнес төлөвлөгөөнөөс гадна компанийн ойрын 5 жилд хийх үйл ажиллагааг төлөвлөсөн стратеги төлөвлөгөөг бэлтгэж, бизнесээ хэрхэн өргөжүүлэх талаар төсөөлөлтэй байх нь бизнес эрхлэгчидэд хөрөнгө, эх үүсвэрээр үр ашиг бизнест хөрөнгө оруулах, зах зээлийн аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг олон талын чухал ач холбогдолтой.

**Бизнес эрхлэгчид бизнес төлөвлөгөө
бичихдээ бэрхшээлтэй тулгардаг уу?**



Бизнес төлөвлөгөө



Өөрийн бизнесийн үндсэн ойлголтыг тодорхойл.

Эмхэтгэн нэгтгэсэн мэдээлэл дээрээ үндэслэн ойлголтоо тодорхойлж тодруул

Төлөвлөгөөгөө анхаарал татах хэлбэрт оруулбал бусдад төвлөрөх боломжыг олгоно.

Таны бизнесийн ойлголтын хэрэгжих боломж, онцгой шинжийн талаар олж чадах бүх мэдээллийг цуглуул

Бизнесийнхээ онцгой шинжийг тоймло, Юу хаана яагаад яаж гэж хандлага хэрэглэх нь ашигтай

Таны төлөвлөгөөнд бизнесийг амжилттай болгоход шаардлагатай хүчин зүйлс орсон эсэхийг шалга



Анхаарал зүйл



Анхаарах зүйлс

Бизнес төлөвлөгөөг зохиохдоо сэтгэл хөдлөлөөр бус бодитоор авч үз. Учир нь та өөрийн бизнесээ хөтлөн явуулах гол үзэл санаагаа боловсруулахад бизнес төлөвлөгөөг ашиглана.

Бизнес төлөвлөгөө танай байгууллагыг үйл ажиллагааны бодит үр дүнг тодорхой хугацааны үеэр хэмжих тул нарийн төлөвлө.

Бизнес төлөвлөгөө чинь нэмэлт санхүүгийн эх үүсвэр олох, нөөцийг бүрдүүлж үр ашигтай ажиллах стратегийн ач холбогдолтой тул хөрөнгө оруулагчдыг тэдний сонирхож буй мэдээллээр бүрэн хангахуйц хэмжээнд боловсруулах.



Энтрeпрeнeруудад зориулсан гарын авлага Цуврал 3



ШИНЖЛЭХ УХААНЫ ПАРК
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Холбоо барих

Мэдээллийн Технологийн Үндэсний Парк
Улаанбаатар- 210646, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-49
Утас: (+976) 11-327123
Факс: (+976) 11-327123
Цахим шуудан: info@itpark.mn

